



МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2025 оны 11 сарын 17 өдөр

Дугаар A/482

Улаанбаатар хот

Засгийн газрын үнэт цаасыг бүртгэлээс хасах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.1.9, "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн Дүрмийн 6 дугаар зүйлийн 6.9.3, "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 23 дугаар зүйлийн 23.1, 23.11.5, "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" хязгаарлагдмал хариуцлагатай компанийн 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 01/1275 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголын хөрөнгийн биржээр арилжигдсан Засгийн газраас гаргасан нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 50,000 ширхэг, 1307 кодтой, богино хугацаат, хямдруулалттай өрийн хэрэгслийн хугацаа дуусаж, төлбөр төлөгдсөн тул "Монголын хөрөнгийн бирж" хувьцаат компанийн үнэт цаасны бүртгэлээс хассугай.
2. Өрийн хэрэгслийг бүртгэлээс хассан тухай мэдэгдлийг "Санхүүгийн зохицуулах хороо" болон "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" хязгаарлагдмал хариуцлагатай компанид тус тус хүргүүлэхийг Хяналт, зохицуулалтын газар (А.Мөнхбаясгалан)-т үүрэг болгосугай.
3. Өрийн хэрэгслийг бүртгэлээс хассан тухай мэдээллийг олон нийтэд хүргэхийг Бизнес хөгжлийн газар (А.Мөнхбаясгалан)-т, цахим хуудас болон арилжааны системд холбогдох өөрчлөлт хийхийг Үйл ажиллагааны газар (И.Жавхлан)-т тус тус даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод хяналтын мэргэжилтэн Ч.Эрдэнэболорт үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Т.ХАШ-ЭРДЭНЭ

1525031011